



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 6 сарын 29 өдөр

Дугаар 254


Улаанбаатар хот

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “Бодь даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 750,000,000.00 /долоон зуун тавин сая/ төгрөгөөр нэмэгдүүлж, хавсралтад заасны дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.
2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Бодь даатгал” ХХК /Б.Мөнххишиг/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн
29 дүгээр тогтоолын хавсралт



“БОДЬ ДААТГАЛ” ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ,
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

(төгрөгөөр)

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эхний үлдэгдэл			Өөрчлөлт			Эцсийн үлдэгдэл		
		Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 1,000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг	Нэмэгдсэн	Хорогдсон	Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 1,000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь
1	Л.Болд ХГ61100473	2,125,272	2,125,272,000.00	50%	375,000	375,000,000.00	-	2,500,272	2,500,272,000.00	50%
2	Л.Болдхуяг ХГ66120475	2,125,272	2,125,272,000.00	50%	375,000	375,000,000.00	-	2,500,272	2,500,272,000.00	50%
	Нийт	4,250,544	4,250,544,000.00	100%	750,000	750,000,000.00	-	5,000,544	5,000,544,000.00	100%